

Дамчаабадгарын Содномжамц¹✉

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн.
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Дөрвөлжин булшны соёлынхны гэзэг үсний заслыг хөшөө чулуу болон хадны зургаас тодруулах нь

Хураангуй. Дөрвөлжин булшны соёлын хүмүүс гэзэг үсээ хэрхэн засаж янзалдаг байсныг тодруулах гол эх сурвалж бол тэдний үлдээсэн булш оршуулга болон хадны зургийн дурсгал юм. Монгол нутагт оршин амьдарч байсан хүрэл, төмрийн түрүү үеийн эртний нүүдэлчид гэзэг үсээ ямар хэлбэрээр засаж гоёдог байсан тухай асуудал судалгааны нэгэн сонирхолтой сэдэв болохын хувьд бид энэ удаад зөвхөн дөрвөлжин булшны соёлын хүрээнд уг асуудлыг тодруулахыг хичээв. Энэ асуултад хариулт олох үүднээс дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх хүмүүсийн дүрслэл, булшнаас зүүн тийш тодорхой зайд босгосон хөшөө чулууны ар тал дахь гэзэгний дүрслэл болон хадны зургийн хүний дүрүүдийг хооронд нь харьцуулан ангилах аргаар судалгааны хэрэглэгдэхүүнээ бүрдүүлж тэдний утга агуулга, үүрэг зориулалт, нас хүйсийг дараах байдлаар тодорхойлов. Судалгааны үр дүнгээс харахад дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх бүжиг мэт хөдөлгөөн хийж буй хүмүүсийг ихэвчлэн булшны хөл эсвэл толгой талын хавтан чулуун дээр дүрслэх нь түгээмэл ба уг ёслолыг голчлон эрчүүд магнайлан гүйцэтгэж байна. Эдгээр хүмүүсийн үс гэзгээ зассан байдлаас харахад эрчүүд үсээ нэгээр, эмэгтэйчүүд хоёр салаа болгон гөрснөөр дүрсэлжээ. Харин хөшөө чулуун дээр нэг салаа гэзгийг дүрслэн харуулж буй нь тухайн булшны эзэн болох эрэгтэй хүнд зориулан босгосон байж болох юм.

Түлхүүр үг. Дөрвөлжин булш, гэзэг үсний засал, хөшөө чулуу, хадны зураг

Sodnomjamts Damchaabadgar¹

¹Institute of Archaeology, ✉
Mongolian Academy of Sciences Building-1.
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Reconstructing the braided hair styles of the slab burial culture from stelae stone and petroglyph

Abstract. The main source for identifying how the people of the Slab burial culture make and style their hair is the monuments of the burial and petroglyph which were left by them. In addition, it is how the ancient nomads of the Bronze and Early Iron age who lived in the territory of Mongolia they make and style their hair the question one of the exciting research topic. Therefore, now we are trying to identify this question only within the context of the Slab burial culture. To find out the answer the question, we analyzed and categorized depiction of people on the enclosure of slab burials, the image of braids on the back side of statue stones erected in the certain distance to the east of the burial, and human figures in petroglyph. Through this comparative method, we determined the meaning, function, and gender of those representations as follows. According to the research results, it is common to find the images of people performing dance-like movements carved on the enclosure stones of slab burials, in many case on slabs at the head or foot of the burials. These ritual scenes are mainly led by men. As viewing by their hairstyles, the men are depicted with a single braid, women are shown with two braids. On the stelae stones, the depiction of a single braid may indicate that the statue was erected in honor of a male individual, possibly the burial's owner.

Keywords. Slab burial, braid hair style, stelae stone, petroglyphic

Удиртгал. Монгол орны өргөн уудам бүс нутагт тархсан хүрлийн хожуу үеийн гол төлөөлөл болох оршуулгын дурсгал бол дөрвөлжин булш юм. Дөрвөлжин булшны соёлын судалгаа тэртээ өнгөрсөн зууны түрүү үеэс эхлэн хийгдэж ирсэн боловч тархалт, ангилал, нэр томъёо, он цаг, угсаа соёлын асуудал бүрхэг хэвээр байна. Гэвч өмнөх судлаачдын гаргасан судалгааны бүтээлүүд дэх санал дүгнэлтүүд нь энэ соёлыг цаашид нарийвчлан судлахад үнэт эх сурвалж болох нь тодорхой бөгөөд дөрвөлжин булшны хавтан чулуун дээрх зургуудад тулгуурлан хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн хадны зургуудыг ялган таних бололцоо бий хэмээн үзэж байна.

Дөрвөлжин булшийг таних хамгийн гол шинж бол түүний гадаад зохион байгуулалт болох тэгш өнцөгт хэлбэрийн босоо хашлага бүхий чулуун дараас билээ. Энэхүү тэгш өнцөгт хэлбэрийн чулуун дараас нь тухайн газар орны хад чулууны онцлог байдлаас хамаарч хашлаганы өндөр, нам харилцан адилгүйн зэрэгцээ зарим булшны хашлага болон хөшөө чулуун дээр хадны зураг сийлсэн байдгийг судлаачид олон янзаар ангилж орон нутгийн онцлог болоод тухайн булшны эзний нийгэмд эзлэх байр суурь талаас нь холбон тайлбарласан байдаг. Сүүлийн жилүүдэд хийгдсэн археологийн судалгааны үр дүнгээс харахад дөрвөлжин булшны соёлын тархалтын хүрээний хойд зах нь ОХУ-ын Өвөр байгаль, баруун болон баруун урд тал нь Говь-Алтайн нуруу, Хангайн нурууны баруун зах, өмнөд зах нь ӨМӨЗО-ны Монь уулын ар, зүүн тал нь Хөлөнбуйрын Далай нуурын Хаа уул, баруун урд тал Шилийн голын Долоннуур хүрч байна. Мэдээж дээр дурдсан зах бүс нутгуудад дөрвөлжин булш харьцангуй цөөн тоотой бол тархалтын голомт бүс нутаг нь Монгол орны төв, зүүн бүс нутаг болох Орхон, Сэлэнгэ, Туул, Онон, Хэрлэн, Тамир, Онги, Түйн зэрэг томоохон голын сав нутаг болно. Дөрвөлжин булшны оршуулгын газруудад дунджаар 3-15 хүртэлх цөөн тооны булштай газар ихэнх хувийг эзлэх бол Туулын хөндийд орших Төв аймгийн Алтанбулаг сумын Эрдэнэхайрхан ууланд 150 (Turbat et al 2009, 93), Морин толгойд 120 (Turbat, Erdenebold 2020, 5), Далай нуурын Хаа ууланд 107 (Feng Enxue 2022, 57), Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Оонод 76, Төв аймгийн Баяндэлгэр сумын Адуун чулуунд 190 зэрэг олон тооны булштай томоохон оршуулгын газруудыг жишээ болгон дурдаж болно.

Дээр дурдан буй асуудлууд нь дөрвөлжин булшны соёлын хүрээнд авч үзэх ерөнхий ойлголтууд ба энэхүү соёлыг үлдээгч ард түмэн хувцас, гоёл чимэглэл тэр дундаа өөрсдийн гээг үсээ хэрхэн засаж бусдаасаа ялгарч байв, аль эсвэл хүрлийн хожуу үеийн олон соёлынхон хоорондоо бүгд ижил байсан уу зэрэг асуудал судалгааны бас

нэгэн сонирхолтой сэдэв болох юм. Гээг үс хэмээх ерөнхий ойлголтын хүрээнд хүний толгой дахь үсийг бүхэлд нь хамруулан ойлгох боловч гээг нь зориуд засаж ургуулсан урт үсийг тусгайлан зааж нэрлэх ба хадны зурагт нэг шулуун эсвэл хоёр салаа болгон дүрслэх нь гөрж сүлжсэн байдлыг илэрхийлсэн хэмээн үзэж байна.

Хэдийгээр дөрвөлжин булшны соёлынхны талаар түүхэн сурвалжид тэмдэглэсэн тодорхой зүйл үгүй тул тэдний угсаа соёлын асуудлыг судлах хамгийн гол эх сурвалж бол булш оршуулга болон хадны зураг болно. Бид дээрх археологийн эх сурвалжуудаас дөрвөлжин булшны соёлынхны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гээг үсний заслын хэлбэрийг тодорхойлж чадваас тэдний угсаа гарвалын залгамж холбооны талаарх асуудалд чухал хэрэглэгдэхүүн болохын зэрэгцээ хадны зургийн зарим дүрслэлийн эзэн холбогдогч болон он цагийн асуудлыг тодорхой баримттай ярих гол түлхүүр болох нь дамжиггүй.

Судалгааны хэрэглэгдэхүүн. Дөрвөлжин булшны соёлынхны оршуулгын зан үйлийн нэг онцлог бол тэд талийгаачийн хойд насандаа амьдрах чулуун гэр болох булшны хашлага чулуун ханан дээр олноороо зэрэгцэн зогсож эсвэл бүжиглэж буй мэт олон хүний дүр, хурьцал үйлдэж буй хосууд, морь хөтлөн зогсож буй хүн, зам мэт шулуун зураас, буга согоо, адуу, шувуу зэрэг ан амьтдыг дүрслэн харуулдаг онцлогтой. Үүнийг судлаачид оршуулгын ёслолын үед хийгдэж байсан элдэв зан үйлийг дүрслэн харуулсан чухал баримт мөн хэмээн үздэг (Sanjmyatav 1988, Novogorodova 1989, Amartuvshin 2002, Batsaikhan 2003, Tsibiktarov 2016, Boldbaatar 2017). Гэхдээ дөрвөлжин булшны соёлын нийт тархалтын хүрээнд авч үзвэл хашлага болон хөшөө чулуун дээрээ дүрслэлтэй дурсгал төдийлөн их биш бөгөөд гагцхүү тухайн бүс нутагтаа томоохонд тооцогдох оршуулгын газарт төлөөлөл болон оршиж байгаа нь магадгүй булшны эзний нийгэмд эзлэх байр суурьтай шууд холбоотой байж мэднэ.

Энэхүү өгүүлэлд ашиглах судалгааны эх хэрэглэгдэхүүнийг цуглуулахдаа дөрвөлжин булшны хашлага хавтан болон булангийн чулуу, мөн булшнаас зүүн тийш зайдуу орших хөшөө чулуун дээр гээг үсийг тодорхой дүрслэн харуулсан 26 булшны материалыг авч ашиглав. Эдгээр ялгаатай талбайнуудад зурагдсан хүний дүрслэлүүдийн учир холбогдлыг тодруулах үүднээс хашлага чулуу (А) болон хөшөө чулуу (В) хэмээн ерөнхий 2 төрөлд хувааж үзэв (Зураг 1).

А төрөл буюу дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх хүний дүрслэл. Дөрвөлжин булшны гол онцлог шинж бол түүний гадаад зохион байгуулалт болох хавтан чулуудыг хавиргалж босгосон тэгш

өнцөгт хэлбэрийн хашлага чулуу болон түүнийг манаж дарсан дараас чулууд мөн болохыг дээр дурдсан билээ. Түүнчлэн зарим булшны дөрвөн булангийн чулууг зориуд бусдаас өндөр хөшөө мэт босгосон тохиолдол ч түгээмэл бий. Хашлага чулууны өндөр нам байх нь тухайн газар орон дахь чулууны олдцоос бүрэн хамаарах (Erdenebaatar 2002) бол зарим газарт өөр газраас зориуд зөөж авчран өндөр хашлага хийсэн тохиолдол ч тэмдэглэгдсэн байдаг (Ulziibayar 2020).

Дөрвөлжин булшны хашлага чулууд дээр хүнийг дүрсэлсэн байрлалуудыг нарийн ажиглан үзвэл тодорхой зүй тогтол ажиглагдаж байна. Тиймээс энэ төрөлд хамаарах дүрслэлүүдийг ойлгомжтой байдлаар тайлбарлах үүднээс дотор нь хашлага чулуун дээрх хүний дүрслэл (Aa) болон булангийн хөшөө чулуун дээрх хүний дүрслэл (Ab) хэмээн дэд хэлбэр болгон ангилав.

Aa хэлбэрт хамаарах хашлага чулуун дээр хүний гэзэг үс дүрсэлсэн тохиолдол хамгийн элбэг байна. Үүнд Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэр уулын Дуган хад, Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын 32 хүнт, 23 хүнт хэмээх дурсгал, Баянхонгор аймгийн Өлзийт сумын Ар өнцөг зэрэг газрууд хамаарна (Зураг 2). Үүнээс гадна Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Тэмээн чулууны ам, Төгрөг сумын Дэл хайрхан, Дорноговь аймгийн Мандах сумын Номтын бууцны дөрвөлжин булшны хашлага чулуун дээр хүний дүрслэлүүд байх боловч гэзэг үсийг нарийн дүрсэлсэн эсэх нь гэрэл зургаас тодорхой мэдэгдэхгүй байна. Ерөнхийдөө эдгээр зургууд нь дөрвөлжин булшны соёлын тархалтын хүрээнд багтах боловч ихэвчлэн монгол орны төв болон говийн зарим бүс нутагт зонхилон тархжээ.

Биндэр уулын дөрвөлжин булшны толгой тал буюу зүүн талын 2 хавтан дээр хүний дүрслэл бий. Эдгээр зургуудыг доктор Ю.Болдбаатарын тодорхойлсноос үзвэл B1-р хавтан дээр зэрэгцэн зогссон 3 хүн, B2-р хавтан дээр 2 эрэгтэй 4 эмэгтэй, 2 согооны дүрс байна (Bolbaatar 2017: 160). B1-р хавтан дээрх хүмүүс нь эрэгтэй хүмүүс байх магадлалтай бол B2-р хавтан дээрх 2 хос 4 хүний хажууд тус бүр 1 эмэгтэйг салаа гээгтэйгээр дүрсэлжээ (Зураг 2-4). Баруун гар талд буй 2 хосын эрэгтэй нь гэзгээ нэгээр гөрсөн бол эмэгтэйн гэзгийг нарийн дүрслээгүй аж. Харин зүүн талд буй 2 хосыг салаалж гөрсөн гээгтэйгээр адилхан дүрсэлсэн нь өвөрмөц юм. Гэхдээ эдгээрийг газар дээр нь очиж дахин нягтлах шаардлагатай. Мөн уг дурсгалыг Б.Даваацэрэн нарын судлаачид Биндэр уулын Дуган хадны дөрвөлжин булш нэрээр судалгааны эргэлтэд оруулсан ба 1 болон 2-р хавтан дээр нийт 13 хүний дүрслэл буйг тэмдэглэн гар зургийг нийтэлжээ (Davaatseren et al 2019: 13).

Энэ хэлбэрт хамаарах дараагийн нэг чухал газар

бол Дэл уулын дурсгал юм. Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уулын “Гучин хоёр хүн хөшөөт булш” хэмээн нэрлэгддэг дөрвөлжин булшийг 1988 онд малтан судалсан (Sanjmyatav 2016: 372) бөгөөд булшны булангийн хөшөө чулуу болон хавтан чулуун дээрх дүрслэлийн утга бэлгэдлийн талаар судлаачид өөрсдийн санал таамгийг дэвшүүлжээ (Volkov 2002). Уг булшны хавтан чулууд дээрх дүрслэлүүдийг дотор нь ангилан тайлбарласнаас бид зөвхөн хүн дүрсэлсэн хэсгүүдийг сонгон авч ашиглав. Үүнд: хөл тал буюу баруун талын A1 хавтан дээр баруун гараа өргөн зүүн гараа тохойгоор нугалан жигд хөдөлгөөнөөр бүжиглэж буй мэт 4 эрэгтэй, хөтлөлцсөн 2 хүн, A2 хавтан дээр өөд өдөөсөө харан хөтлөлцсөн эрэгтэй, эмэгтэй 2 хүн, хойд тал буюу толгойн талын B1 хавтангийн дээд ирмэг дээр 6 хэсэг газарт 21 эрэгтэй, 8 эмэгтэй нийт 29 хүн, B2 хавтангийн ирмэг дээр 3 хэсэг газарт 11 эрэгтэй, 3 эмэгтэй нийт 14 хүнийг тус тус дүрсэлжээ (Болбаатар 2017: 164-166). Дээрх дүрслэлүүд дотор A2 хавтан дээр хөтлөлцөн зогссон 2 хүний эрэгтэйн гэзгийг нэг шулуунаар, эмэгтэйг салаа гээгтэйгээр зурсан ба мөн эр, эм бэлэг эрхтнийг тодруулан ялгажээ (Зураг 2-1, 2). Ингэж гэзэг үсийг ялган зурсан бусад дүрслэлүүдээс харахад баруун гараа өргөн бүжиг хийж буй хүмүүсийн гэзгийг нэгээр гөрж эр бэлэг эрхтнийг онцолжээ. Тэгэхлээр уг булшны хавтан дээр зурагдсан гараа өргөн бүжиг мэт үйл хөдлөл хийж буй ёслолд дандаа эрэгтэй хүмүүс оролцсон болох нь төвөггүй мэдэгдэнэ.

Бид 2018 онд Монгол-Хятадын хамтарсан хээрийн судалгааны ажлын хайгуулын явцад Баянхонгор аймгийн Өлзийт сумын Ар өнцгийн дурсгалт газарт тоногдсон байдалтай олон тооны дөрвөлжин булш байсныг авран хамгаалж зарим булшийг малтан судалсан юм. Ар өнцгийн 2-р дөрвөлжин булшны хөл тал буюу баруун талын хавтан чулууны гадагш харсан гадаргуу дээр зогсоо байдалтай 14 хүний дүрслэл бий (Wang Lixin et al, 2023: 14). Үүнээс гол хэсэгт зогссон 6 хүнийг баруун гараа дээш өргөн зүүн гараа ташаандаа тулсан байдлаар, баруун зүүн талын хүмүүсийг 2 гараа ташаандаа тулан зогсоо байдлаар дүрсэлжээ. Эдгээрээс зүүн гар талд буй 2 хүний толгойд нэг шулуун зураасаар гэзгийг төлөөлүүлэн зурсан бол бусад хүмүүсийн гэзэг үсийг тодорхой дүрслээгүй нь магадгүй зурах зай талбай хязгаарлагдмал байдлаас хамаарсан байж мэдэх юм. Харин эдгээр хүмүүсийн доод талд хурьцал үйлдэж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг дээрээс харсан байдлаар зуржээ. Ингэхдээ эмэгтэйг 2 хөлөө өвдгөөр нь нугалж, үсийг 2 салаалж гөрсөн бол эрэгтэйн гэзгийг нэгээр гөрж дүрсэлжээ. Үүнээс үзвэл гол хэсэгт зогсоо байдалтай 14 хүн нь бүгд эрэгтэй хүмүүс байх боломжтой байна (Зураг 2-3).

Ab хэлбэрт дөрвөлжин булшны булангийн хөшөө чулуун дээрх хүний дүрслэлүүд хамаарах ба үүнээс гээг үсийг тодорхой харуулсан зураг Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Хар чулуут (Bayarsaikhan et al 2012: 21), Баянхонгор аймгийн Өлзийт сумын Чулуун онгоцотын 6-р булш, Ар өнцгийн 2-р булш (Batsaikhan et al 2018: 41) зэрэг одоогоор хамаарч байна (Зураг 3).

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Хар чулуутын дөрвөлжин булшны зүүн урд талын булангийн хөшөө чулуун дээр 2 буга, 1 согооны дүрслэл байх ба тэдгээрийн баруун дээд буланд зэрэгцэн зогсож баруун гараа ташаандаа тулж, зүүн гараа дээш өргөсөн 3 эрэгтэй хүний дүрслэл бий. Эдгээр хүмүүс нь гэзгээ нэг шулуунаар гөрсөн байдлаар тодорхой ялган харуулжээ (Зураг 3-1).

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Чулуун Онгоцотын 8-р дөрвөлжин булшны баруун урд талын булангийн хөшөө чулууны гадна талд бугын доод талд 5 хос нийт 10 хүний дүрслэл бий. Хөшөө чулуу нь орой хэсгээрээ хугарсан боловч бугын эх бие болон эвэр тодорхой мэдэгдэх бол цээжин дор нь нэгэн амьтны бөгсөн бие, хүмүүсийн доод талд өөр нэг амьтны үл танигдах дүрслэл бий. Эдгээр хүмүүсийг баруун доод булангаас нь №1 хэмээн дугаарлаж дараах байдлаар тодорхойлов. 1-р хосыг дээрээс харсан байдлаар зурсан ба эмэгтэйг дээд талд нь салаа гээгтэй, эрэгтэйг доод талд 1 шулуун гээгтэйгээр хоорондоо хурьцал хийж буйгаар дүрсэлжээ. 2-р хосын эрэгтэйг зогсоо байдлаар зүүн гартаа нум барьж буга руу харваж буйгаар зурсан ба толгойн ар талд нэг шулуун гээг болон толгойн орой хэсэгтээ урагш бага зэрэг унжсан гөхөлтэй. Харин эмэгтэйг түүний урд талд хоёр хөлөө өвдөг хэсгээр нугалсан байдлаар урт салаа гээгтэйгээр дүрсэлжээ. 3-р хосыг дээрхтэй адил эрэгтэйг зогсоо байдлаар нэг шулуун гээгтэйгээр, эмэгтэйг урд талд нь хэвтсэн байдлаар салаа гээгтэйгээр дүрслэхдээ эрэгтэйн зүүн гарын сарвууны хурууг тодорхой ялган харуулсан байна. 4-р хосыг бугын хэвлий хэсгийн доор зурахдаа эрэгтэй нь нуруу хэсгээрээ бага зэрэг бөгийж зогсоо байдлаар нэг шулуун урт гээгтэйгээр, эмэгтэй нь салаа гээгтэй ба хөлөө өвдгөөрөө нугалж хэвтсэн байдлаар харуулжээ. Мөн эмэгтэйн толгой хэсгийг бугын эр бэлэг эрхтэнтэй холбогдсон байдалтай дүрсэлсэн байна. Урлаач уг зургийн сэдэв зохиомжийг гаргахдаа эхлээд бугыг дараа нь доод талын хүмүүсийг, хамгийн сүүлд үлдсэн зайд тааруулан 4-р хосыг зурсан байж болно. 5-р хос дүрслэлийн хувьд өмнөх дүрслэлтэй ижил боловч эрэгтэй нь зогсож нэг гараараа эмэгтэйн гэзэгнээс барьснаар харуулжээ (Зураг 3-2).

Дээрх тодорхойлолтоос үзэхэд хурьцал хийж буй хүмүүсийн хүйсийн байдлыг ялгах гол шинж бол эрэгтэй, эмэгтэй хүний үсний засал болон

бэлэг эрхтнийг ялган дүрсэлсэн байдал юм. Энэхүү зурагт эрэгтэй хүний толгойн ар талд нэг шулуун гээг, хөлийн хооронд эр бэлэг эрхтнийг нарийн зураасаар ялган зурсан бол эмэгтэй хүнийг салаа гээгтэй, хөлөө алцайж, эм бэлэг эрхтний уруулыг салаалсан байдлаар нарийн дүрсэлсэн нь ховор тохиолдол болохын зэрэгцээ хүйсийг ялган таних гол шинжүүд юм.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Ар өнцгийн дурсгалт газрын 2-р дөрвөлжин булшны толгой тал буюу зүүн урд талын булангийн хөшөө чулууны гадна талын гадаргуу дээр буга, согоо, 4 адуу, янгир зэрэг амьтдын дүрслэлийн баруун доод буланд гар гараасаа хөтлөлцөн зогссон 2 хүний дүрслэл бий. Баруун талын хүн 2 салаа гээгтэй бол зүүн талын хүн бага зэрэг бөхийсөн байдлаар дүрсэлжээ. Мөн зүүн хойд талын булангийн хөшөөний дотор талын гадаргуу дээр адуу хөтлөн зогссон 2 хүн, түүний доор унагатай гүү, тэдгээрийн баруун талд хөтлөлцөн зогссон 2 хүний дүрслэлтэй. Баруун талын хүнийг салаа гээгтэйгээр дүрсэлсэн нь эмэгтэй хүн бололтой. Хүмүүсийн хажууд хөвөөлдөн дутуу цохисон адуутай төстэй амьтны дүрслэл байна (Зураг 3-3, 4).

Дээрхээс гадна Дорноговь аймгийн Мандах сумын Номтын бууцны дөрвөлжин булшны орчимд байрлах нэгэн хавтан чулуун дээр хос шулуун зураасан замын хоёр талд тэрэг, морь хөтөлсөн хүмүүс болон тэдгээрийн ар талд зогссон 8 хүний дүрслэл бий. Эдгээрээс зогсоо байдалтай 8 хүний дотор 3 хүний гэзгийг нэгээр гөрснөөр зуржээ.

В төрөл: Дөрвөлжин булшны хөшөө чулуун дээрх дүрслэл. Монгол, Өвөр байгаль болон Хөлөнбуйрын тал нутагт тархсан дөрвөлжин булшны соёлын хүрээнд булшнаас зүүн тийш ойролцоогоор 7-15 метрийн зайд хөшөө чулуу босгох зан үйл хэд хэдэн оршуулгын газруудад ажиглагддаг. Үүнийг судлаачид янз бүрээр тайлбарлаж ирсэн ба хүнийг дүрсэлсэн хөшөө чулуу (Perlee 1977: 14-19, Tsi-biktarov 2016: 283-293), зүг эрхэмлэх ёс (Navaan 1975: 131, Davaatseren et al 2011: 34) харуул чулуу (Dikov 1958, 63), сэргэ чулуу (Turbat 2000: 290-296) зэрэг саналууд бий. Монгол болон ОХУ-ын нутагт нийт 46 дурсгалт газарт хөшөө чулуутай дөрвөлжин булш мэдэгдэж (Bemmann, Brosseder 2017: 22-23, pic 8) байсан нь сүүлийн жилүүдэд энэ тоо эрс өссөн байна. Доктор С.Өлзийбаяр нарын судлаачид Дорнод Монголын дөрвөлжин булшны хөшөө чулуудыг дотор нь шон чулуу (түрүү шинжтэй), шон чулууны уламжлалт хөшөө (сонгодог хэлбэр), хүн хэлбэрт хөшөө (төгсгөл үе) хэмээн ангилж ерөнхийдөө хүнд зориулан босгосон хөшөө гэж үзжээ (Ulziibayar et al 2020: 17-18).

Харин бидний судлан буй сэдвийн хүрээнд авч үзвэл дөрвөлжин булшны зарим хөшөөний ар талд буй нарийн шулуун зураасан дүрслэлүүд

Хүснэгт 1. Дөрвөлжин булшны хашлага, булан чулуу болон хөшөө чулуун дээрх хүмүүсийн дүрслэлийг хүйсээр ялгасан байдал.


№	Дурсгалт газар	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй
1	Дундговь, Өлзийт, Дэл уул, 32 хүнт хэмээх дөрвөлжин булшны хашлага чулуу		
2	Баянхонгор, Өлзийт, Чулуун Онгоцот, 8-р дөрвөлжин булшны булангийн чулуу		
3	Баянхонгор, Өлзийт, Ар өнцөг, 2-р дөрвөлжин булшны хашлага чулуу		
4	Хэнтий, Батширээт, Биндэр овоо, Дугана үзүүрийн дөрвөлжин булшны хашлага чулуу		
5	Дундговь, Эрдэнэдалай, Хар чулууны дөрвөлжин булшны булангийн чулуу		
6	Төв, Эрдэнэсант, Салхитын дөрвөлжин булшны хөшөө чулуу		

нь гэзэг үстэй шууд холбогдоно. Дөрвөлжин булшны хөшөө чулуун дээрх энэхүү дүрслэлийг гэзэг гэж Х.Пэрлээ гуай анх тодорхойлсон бөгөөд Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэр уул, Мөрөн сумын Чандган талын Өртөөн дэв (Perlee 1977: 15-16), Дорнод аймгийн Гурванзагал сумын Хөцөөгийн 2-р хүн чулуу (Tumen et al 2009: 79), Чулуунхороот сумын Үхэрт (Davaatseren et al 2011: 34), Өмнөговь аймгийн Манлай сумын Замтын хөтөл (Bayarsaikhan et al 2013), Анхабайн 1, 4-р булш (Tsibiktarov 2016: 290) Баянхонгор аймгийн Өлзийт сумын Чулуун Онгоцот (Batsaikhan 2018: 13), Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Өгөөмөр уул, Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Дэл хайрхан (Sodnomjamts et al 2024: 32) Төв аймгийн Баяндэлгэр сумын Адуун чулуу зэрэг дурсгалт газрын дөрвөлжин булшны хөшөө чулуун дээр гэзэг дүрсэлжээ. Эдгээрийн дотроос Биндэр уул орчмоос 20 гаруй хөшөөтэй дөрвөлжин булш бүртгэснээс 9 хөшөөн дээр гэзэг дүрсэлсэн байгаа нь хамгийн баялаг хэрэглэгдэхүүнд одоогоор тооцогдоно. Гэзгийг ихэвчлэн хөшөөний ар талын дээд хэсэгт дугуй хонхор дүрсээс доош унжсан шулуун

зураасаар хонхойлгон цохих аргаар дүрслэн харуулдаг. Гэхдээ уг дүрсийг нарийн ажиглаж үзвэл дүрслэлийн хувьд дотроо 2 өөр хэлбэрт ангилж болохоор байна (Хүснэгт 2). А хэлбэрийн гэзэг нь дугуй хонхор дүрсээс доош салаалсан нарийн зураас бүхий алх мэт тойм дүрслэлтэй бол В хэлбэр нь дээрхтэй төстэй боловч доош унжсан нарийн зураасан дээр хөрөөний шүд мэт хөндлөн богино зураас нэмж сийлсэн нь гэзгийг гөрсөн байдлыг илэрхийлсэн бололтой. Мөн Биндэр уулын Ханан, Чандган талын Өртөөн дэвийн дөрвөлжин булшны хөшөө чулууны гэзэгний үзүүрт зүүлт зүүсэн байдлаар дүрсэлсэн хэмээн тэмдэглэснийг онцлон дурдах хэрэгтэй (Perlee 1977: 16). А хэлбэрийн гэзэгний дүрслэл Үхэрт, Биндэр уулын 2, 6, 7, 8-р хөшөө, Чулуун онгоцотын 1, 2-р хөшөө, Өгөөмөр уулын 1-р хөшөөнд байгаа (Зураг 4) бол В хэлбэрийн гэзэгний дүрслэл Биндэр уулын 3, 5-р хөшөө, Хөцөөгийн 2-р хөшөө, Замтын хөтөл, Адуун чулуу зэрэг газруудын хөшөө чулууны ар талд байна (Зураг 5). Нэг тохиолдолд Биндэр уулын 4-р хөшөөний хоёр хажуу талд тус бүр нэгээр гөрсөн гэзэг дүрсэлжээ. Түүнээс гадна Булган

аймгийн Баяннуур сумын Салхитын дөрвөлжин булшны хөшөөнд баруун гараа тохой хэсгээр өргөж зүүн гараа доош унжуулж хөлөө жийсэн байдалтай салаа гэээгтэй эмэгтэй хүнийг дүрсэлсэн байна (Ankhsanaa 2023: 12).

Хүснэгт 2. Дөрвөлжин булшны хөшөө чулуун дээрх гэээгний үндсэн хэлбэрүүд

Гэээгний хэлбэр	
А хэлбэр	В хэлбэр
	
Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр	Өмнөговь, Манлай, Замтын хөтөл

Судалгааны хэлэлцүүлэг. Бид энэ удаад Монгол нутгаас илэрч олдсон дөрвөлжин булшны хашлага чулуу, булангийн чулуу, хөшөө чулуу зэрэгт дүрслэгдсэн хүмүүсийн байрлал, хөдөлгөөн болон гэээг үсний талаар дараах саналыг хэлэлцүүлж байна. Одоогоор нийтлэгдсэн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд 10 дурсгалт газрын дөрвөлжин булшны хашлага болон булангийн чулуунд бүжиглэж буй болон хурьцал хийж буй хүмүүсийн дүрслэл бий. Үүнээс Тэмээн чулуу, Номт, Авдрантын хүнхэр, Дэл уулын 32, 23 хүнт, Ар өнцөг зэрэг 6 газрын дөрвөлжин булшны баруун тал буюу хөл талын хавтан чулуунд, Биндэр уулын Дуган хад, Дэл уулын 32 хүнт гэсэн 2 газрын дөрвөлжин булшны зүүн тал буюу толгой талын хавтан чулуунд, Чулуун онгоцотын 6-р булшны баруун урд булан, Хар чулуутынх зүүн урд булангийн хөшөө чулуунд тус тус ялгаатай дүрслэгджээ. Хэдий цөөн боловч дээрх баримтаас харахад ихэвчлэн хөл талын хавтан чулуунд нэг гараа дээш өргөн ямар нэгэн зан үйл гүйцэтгэж буй хүмүүсийг дүрслэх тохиолдол давамгайлж байна.

Эдгээр хүмүүсийн дүрслэлээс харахад аль талын хавтан чулуун дээр дүрслэхээс үл хамаарч баруун эсвэл зүүн гараа дээш өргөж ямар нэг зүйл барьсан мэт ба эдгээрийг мөн доорх байдлаар ялган үзэв. Үүнээс Ар өнцгийн 2-р булш, Дэл уулын 32 хүнт, Тэмээн чулууны булш зэрэг 3 газарт баруун гараа өргөж зүүн гараа ташаандаа эсвэл тохойгоор нугалж унжуулсан байгаа бол Дэл уулын 23 хүнт, Авдрантын хүнхэр, Номт, Хар чулуут зэрэг 4 газарт зүүн гараа дээш өргөж, баруун гараа ташаандаа эсвэл тохой хэсгээр нь нугалж унжуулсан байна. Үүнээс гадна Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Дэл хайрхны дөрвөлжин булшны урд талын голын хашлага дээр баруун гараа ташаандаа авч зүүн гараа

унжуулсан байгаа нь дээрхээс ялгаатай. Ямартай ч зүүн гараа өргөн бүжиг мэт хөдөлгөөн хийх тохиолдол давамгайл байна. Мэдээж аль талын гараа дээш өргөхөөс хамаарч тухайн хүмүүсийн явж буй чиглэл өргөсөн гарын чигт байх нь ойлгомжтой юм.

Ерөнхийдөө дөрвөлжин булшны хавтан чулуун дээрх эдгээр дүрслэлүүд нь бүхэлдээ оршуулгын явцад хийгддэг гашуудлын зан үйлийн хэлбэрүүд хэмээн тодорхойлж болно. Бидний дээрх харьцуулсан судалгаанаас харахад баруун эсвэл зүүн гараа өргөн зогсож буй хүмүүсийг ихэвчлэн талийгаачийн хөл эсвэл толгойн талын хавтан чулууны гадна талд дүрслэх ба эдгээр зан үйлийг эрчүүд голчлон гүйцэтгэж байна. Харин эдгээр бүжиг хийж буй хүмүүсийн хажууд эсвэл ойролцоо хурьцал хийж буй хүмүүс, буга согооны дүрслэл байгаа нь нарийн утга бэлгэдэлтэй судалгааны тусдаа асуудал учир энэ талаар дараа дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Дээрх баримтуудыг нэхэн тодруулахад дундад эртний үеийн түүхэн сурвалж, хана туурганы чимэглэл зураг болон угсаатны зүйн зарим мэдээнүүд тус дөхөм болох нь тодорхой юм. Тухайлбал БНХАУ-ын Шинжааны нутагт орших 224-р агуйн хананд НТ 550-560 оны үед хамаарах бурхны шашинт Уйгуруудыг дүрслэн харуулсан бурхан багш нирваан дүр үзүүлсэн нь хэмээх сэдэвт ханын зурагт баруун эсвэл зүүн гараа өргөж, нүүрээ хутгаар зүссэн зэрэг гашуудлаа илэрхийлж буй зураг, XIV зууны үеийн Их Монголын “Шахнамэ” хэмээх судрын “Исфандиерын шарилын цуваа” хэмээх зурагт гашуудлын цувааг дагагчид үс гээгээ задгайлан, гараа алдлан тэнгэрт хандан бэдрэх (Erdenebat 2024: 74, 84) ба энэ зан үйл магадгүй хүрлийн үеэс эхлэлтэй гашуудлын дохио байж мэднэ. Баруун гараа өргөж зүүн гараа тохой хэсгээр нугалан зан үйл (бүжиг) хийж буй байдлыг харуулсан хадны зураг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хар чулуутын цогцолборын ХЧ-219-р хавтан дээр дүрслэгдсэн байна (Kovalev, Munkhbayar 191, 197).

Дөрвөлжин булшны соёлынхонд гэээг үс дүрсэлсэн байдлаас үзэхэд булшны хашлага чулуун дээрх хүмүүсийн дотор эрчүүд нь үсээ арагш нэгээр, эмэгтэйчүүд нь хоёр салаагаар боож гөрсөн байдал тодорхой мэдэгдэнэ. Харин хөшөө чулууд дээр бүгд нэг шулуунаар гөрсөн байгаа нь эрэгтэй хүнийг төлөөлүүлэн хийсэн байж болох юм. Ер нь эрчүүд үсээ нэг шулуунаар гөрж боох засал одоогийн байдлаар хамгийн эртнийх нь хүрлийн түрүү үеийн Хэмцэгийн соёлын (2600-1800) хүн чулуун хөшөөнүүдэд тодорхой дүрсэлжээ. Тухайлбал Шинжааны нутгаас олдсон Кайнар 2 №1, Чемурчек 2008 №1, Сентасын хүн чулуун (Kovalev 2012, 21, 63, 99) хөшөөнүүдийн ар талд үсийг нэг шулуунаар гарган үзүүрт нь боолт

дүрсэлжээ. Харин хүрлийн дунд болон хожуу үеийн бусад дурсгалуудад гэзэг үс тодорхой дүрсэлсэн зүйл одоогоор цөөн боловч Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Жаргалантын ам болон Ховд аймгийн Мөст сумын Баянзүрхийн буган хөшөөнд нэг шулуунаар гөрсөн гэзэгний дүрслэл бий (Gantulga 2021: 120) (Зураг 6).

Судлаачид буган хөшөөг хүнчилсэн дүр бүхий баатар эрд зориулсан дурсгал мөн хэмээн үздэг билээ (Volkov 2002, Bayarsaikhan 2017, Turbat 2021). Харин дөрвөлжин булшны хөшөө чулуун дээр буган хөшөөний зарим дүрслэлүүдтэй ижил утга агууламж бүхий дүрслэл байна. Тухайлбал хөшөөний нүүрэн талд хүний нүүр, ташуу зураас, хүзүүний зүүлт, бүс, хоёр хажуу талд цагариг болон унжлагатай ээмэг, ар талд гэзэг үс зэргийг дүрсэлнэ. Харин буган хөшөөнөөс ялгарах гол онцлог нь буга болон бусад араатан амьтдыг дүрслэхгүй байгаад оршино. Тэгэхлээр дөрвөлжин булшны хөшөө чулууд нь тухайн булшны эзэнд буюу хүнийг төлөөлүүлэн хийсэн хүн чулуу ба магадгүй эрэгтэй хүнд түлхүү зориулан босгож байжээ. Үүнд холбогдуулан авч үзэх нэгэн баримт бол Баянхонгор аймгийн Өлзийт сумын Чулуун онгоцотын 1, 2-р дөрвөлжин булшны хөшөө чулууд нь нэг шулуун зураасаар дүрсэлсэн гэзэгтэй ба уг хоёр булшны малтлагаас гарсан хүний ясанд хийсэн палеоантропологийн судалгааны үр дүнгээс үзэхэд 45-50 насны эрэгтэй хүмүүсийнх байжээ¹.

Хүрлийн үеийн эртний нүүдэлчид гэзэг үсээ хэрхэн засаж янзалдаг байсан тухай ямар нэг бичгийн эх сурвалж одоогоор мэдэгдээгүй тул үүнийг тодруулах ганц боломж бол хадны зураг юм. Гэвч ихэнх хадны зурагт хүнийг тойм байдлаар дүрслэх хэдий ч дээр дурдсан дөрвөлжин булшны хавтан чулуу, хөшөө чулуун дээр дүрсэлсэнтэй ижил төстэй гэзэгтэй хүмүүсийг дүрсэлсэн баримтууд цөөнгүй тэмдэглэгджээ. Тухайлбал эрэгтэй хүнийг нэг салаа, эмэгтэй хүнийг хоёр салаа гэзэгтэйгээр дүрсэлсэн хадны зураг Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайт, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул (Okladnikov 1981: 4, 38, 37), Гучин-Ус сумын Паалуу (Tseveendorj 2020, 312), Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын Баруун Билүү зэрэг дөрвөлжин булшны соёлын тархалтын хүрээнд хамаарах газруудад байна (Зураг 7). Эдгээрээс Тэвш уулын хадны зурагт зэрэгцэн зогссон хоёр хүний эмэгтэйг хоёр салаа гэзэгтэй, эрэгтэйг нэг шулуун зураасаар арагш намирсан байдлаар зурсан ба хөлийн хооронд эр, эм хүйсийг ялгасан эрхтнийг нарийн дүрсэлжээ. Мөн эрэгтэйн ар талд түүний гэзэгнээс барих гэж буй байдлаар алслал гарган нэгэн эмэгтэйг

дүрсэлсэн ба гэзгээ хоёр салаалан эргүүлэн дээш боосноор зурсан нь үсний заслын өвөрмөц хэлбэр бөгөөд дундад зууны үеийн шибилгэр гэзгийг санагдуулна. Мөн Дэл уулын Баруун Билүүний хадны зурагт хурьцал хийж буй хосын эмэгтэй рүү нум сум агссан өөр нэгэн эр харвах гэж буй байдлаар зурсан нь тухайн үеийн хүмүүсийн гэр бүлийн харилцааны асуудлыг илэрхийлсэн сэдэв агууламжтай байж болох ч судлан буй сэдвийн хүрээнд авч үзвэл хүмүүсийн гэзэг үсний заслын хувьд дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх дүрслэлүүдтэй ижил байна.

Харин дөрвөлжин булшны соёлын хүрээнд хамаарахгүй боловч ойролцоо цаг хугацаанд өөр бүс нутгуудад зурагдсан олон тооны хадны зураг бий. Тухайлбал Баян-Өлгийн аймгийн Улаанхус сумын Цагаан салаа, Бага Ойгур (Kubarev et al 2005), Шивээт хайрхан (Tseveendorj et al 2010), Далан Түргэний хос толгой (Tserendagva, Tseveendorj 2016, 53), Буянт сумын Хойд Хөлцөөт (Umirbek 2024, 70) зэрэг Монгол Алтайн нурууны хадны зургийн томоохон дурсгалт газруудад мөн адил гэзэг үсний заслын хэлбэрийг харуулсан цөөнгүй дүрслэлүүд бий. Ерөнхийдөө дээрх газруудын хадны зурагт эрчүүдийг зэр зэвсгээ агсаж ан ав, дайн тулаан хийж буй байдлаар харуулахдаа мөөгөн/саран хэлбэрийн малгайтайгаар дүрслэх тул ихэнх зурагт гэзэг үсээ хэрхэн зассаныг төдийлөн нарийн гаргаагүй байна. Гэхдээ Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Далан Түргэний хос толгойн 485-р зурагт саран хэлбэрийн малгай өмсөж гэзгээ ар тийш унжуулж үзүүрийг нь боосон байдлаар зурсан нь (Tserendagva, Tseveendorj 2016, 53) эрэгтэй хүний гэзэгний хэлбэрийг тодорхой харуулсан нэгэн жишээ юм. Мөн Цагаан салаа-2 дурсгалын 118-р зурагт морин дээрээ зогсон янгир харваж буй эр, Шивээт хайрхны 25-р зурагт өөд өөдөөс харан тулан зогсож буй 2 эр, 309, 319-р зурагт янгир харваж буй анчид, 316-р зурагт морин дээрээс нум харваж хүн зэргийг нэг салаа гэзэгтэйгээр дүрсэлсэн байна. Харин Шивээт хайрхны 10-р зурагт эрэгтэй, эмэгтэй, хүүхэд гурвын үсийг олон салаа болгон гөрсөн байдлаар харуулсан нь өвөрмөц тохиолдол юм (Зураг 8).

Монгол Алтайн хадны зурагт эмэгтэй хүнийг салаа гэзэгтэйгээр дүрслэх нь хүйсийг ялгах гол шинж болохын зэрэгцээ цээжний хэсгийн хажууд дугуй хонхор, жирэмсэн бололтой гэдсийг тод харуулах, хоёр хөлийн хооронд голдоо хонхортой зууван дугуй гаргах зэргээр хүйс илэрхийлж үржлийг бэлгэдсэн (Umirbek 2024, 70) зургууд түгээмэл тохиолддог. Ялангуяа Цагаан салаа, Бага-Ойгурын хадны зурагт нуруу ачсан үхэр хөтлөн зогсож буй болон үхэр унасан эмэгтэй хүний дүрслэл олон (Kubarev et al 2010) бөгөөд үүнтэй төстэй зургууд монгол орны зүүн бүс нутгаас бусад

¹ Хүний ясны палеоантропологийн судалгааг МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн багш, доктор, профессор М.Эрдэнэ хийсэн болно.

газарт тэмдэглэгдсэн байдаг нь мал аж ахуйн үүсэл хөгжлийн эхэн үед үхэр нь тээвэрт чухал үүрэг гүйцэтгэж байсны илрэл гэжээ (Tuvshinjargal 2022, 135). Харин эдгээр үхэр унасан болон хөтөлсөн хүмүүс нь ихэвчлэн салаа гээгтэй хүмүүс байгаа нь эм хүйсийг шууд илтгэхийн зэрэгцээ үхэр нь адууг бодвол номхон дөлгөөн, явдал зөөлөн тул нүүдлийн үед ихэвчлэн эмэгтэйчүүд унах, хөсгийг хөтлөх, ачаанд хүүхдээ тээвэрлэх зэргийг голчлон гүйцэтгэж байжээ.

Ерөнхийдөө Монгол Алтайн хадны зурагт эрэгтэй хүний гээгийг нэг салаагаар, эмэгтэй хүнийг хоёр салаа болгон гөрсөн олон баримт байх нь нэг талаар Монголын төв, зүүн бүс нутгаар тархсан дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх дүрслэлүүдтэй ижил мэт байвч эдгээр нь хоорондоо ямар нэг угсаа соёлын холбоотой гэсэн үг биш юм. Мөн зарим тохиолдолд эрэгтэй хүнийг бас салаа гээгтэй байдлаар дүрсэлсэн тохиолдлууд цөөнгүй байгаа нь он цагийн ялгаа хэмээн тайлбарлаж болох бөгөөд Укокийн Верх-Кальджин-2 дурсгалын 3-р булшнаас гарсан эрэгтэй хүний занданшуулсан шарилаас хоёр салаа болгон гөрсөн гээг гарсан тохиолдол бий (Polosimак 2001, 247).

Дөрвөлжин булшны соёл нь хүний антропологи төрх, оршуулгын зан үйлийн зарим талаараа Хүннү нартай шууд холбоотой хэмээн үздэг. Хүннү нарын гээг үсний тухай Хан улсын сударт буй мэдээг Г.Сүхбаатар гуай алх (балт) мэт боосон үс гэдэг нь бие дагуулан унжуулсан гээг гэж тайлбарласан байдаг (Sukhbaatar 1980: 137). Мөн хожуу Хан улсын судрын Ухуаны заншилд “...Мулзан толгойг ая тух хэмээнэ. Бүсгүй хүмүн харьд мордохын үе гээг үсээ чимж, шанхлан ороож хатгамал хатган, алт, хашаар чимсэн гоуцзюэ өмсөх нь...” гэсэн мэдээ бий (Ganbold 2020: 110). Харин археологийн баримтаас үзвэл Ноён уулын хүннүгийн булшнаас 2 болон 3-р гөрсөн болон сүлжилгүй боосон урт гээг Козловын малтсан булшнаас 120 гаруй, 1-р булшнаас 21, 6-р булшнаас 85, Кондратьевийн булшнаас 14, 20-р булшнаас 2 гээг гарсан байдаг. Эдгээр гээгийг С.А.Теплоухов, С.И.Руденко нар эмэгтэй хүнийх гэж үздэг бөгөөд өөрийн эзнийг нас барьсны дараа гашуудлаа илэрхийлж тахил болгон өргөсөн ба үсний ширхэг, өнгө, сүлжсэн хэлбэр зэргээрээ олон төрөл байгаа тул янз бүрийн овог аймгаас төлөөлөл болгон дагалдуулсан гэжээ (Polosimак, Bogdanov 2015, 65-67). Ноён уулын булшнаас гарсан дээрх гээгийг чухам эрэгтэй эсвэл эмэгтэй хүмүүсийн аль нь болох, цаашлаад хүннү нарынх мөн үү гэдэг асуудал лабораторийн нарийвчилсан судалгаагаар шийдэгдэх биз. Ямартай ч малтлагаас гарсан хэрэглэгдэхүүнээс үзэхэд гөрсөн эсвэл боосон байдалтай гээгүүдийн хамгийн урт нь 66 см, өргөн нь 4 см бол хамгийн богино гээг 15 см урт, 2.5 см өргөнтэй (Erdene-

Ochir et al 2021, 335) байгаа нь янз бүрийн насны хүмүүсийн төлөөлөл байж мэднэ.

Хүннүгийн булшнаас биетээр олдсон дээрх гээг болон сурвалжийн мэдээ зэргээс үзэхэд тэд үс гээгээ сүлжиж унжуулдаг хэмээн дүгнэж үзэх бүрэн үндэстэй юм. Үс гээгээ гөрж боох энэ хэлбэр нь Төв Азийн байгаль цаг уурын өвөрмөц байдал болон тэдний эрхлэх аж ахуйтай нягт уялдан бий болсон гэдэг нь ойлгомжтой (Erdenebat, Bayar 2011: 161) ба одоогийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд эрчүүд нэг, эмэгтэйчүүд хоёр салаа болгон гөрөх хэлбэр ямартай ч хүрлийн түрүү үеэс эхлэн бий болж хиргисүүр, буган чулууны соёлыг дамжин улмаар дөрвөлжин булшны соёлынхонд гүн ул мөрөө үлдээж цааш эртний төрт улсуудад уламжлагдан хөгжжээ.

Угсаатны зүйн зарим мэдээнээс үзэхэд сонирхолтой зүйлс олныг тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал баяд сэвгэр айлын бэр болж мордохын урьд эцгийн гал голомтын зүүн дээд биед сууж, охин үсээ задлан хоёр салаа гээг болгох ёс үйлдэхийг “гээг тавих” гэж нэрлэх ба *хорин салаа гээгийг хоёр салаа болгож тавих* гэсэн яриа бий (Batnasan 1996). Яг үүнтэй төстэй зан үйл Алтайн урианхай нарын хуримын зан үйлд “гээг буулгах” нэртэйгээр тэмдэглэгдсэн ба охины гэрт түүний ойрын ах дүү нар нь цугларч, охин олон салаа гөрсөн үсээ задлаад хоёр салаа болгон сүлжиж унжуулдаг (Badamhatan, Lhagvasuren 1996). Харин хотон ёсонд охиноо хадамд очиход 5 салаа үсийг нь 2 салаа болгон гөрж “чачваг” зүүлгэнэ гэсэн бол Тувачуудын заншлаар бэр ирэхдээ гурав гурваар дөрвөн хэсэг болгон сүлжсэн 12 салаа гээгтэй ирдэг. Хүргэн талд ирээд үсийг нь задалж нөхөр болох залуугийн гээгтэй нийлүүлж гурван удаа самнах ёс гүйцэтгэнэ. Тэгээд хүүхний гээгийг хоёр салаа болгон сүлжиж үсний уутанд хийн толгойн хоёр талаар унжуулна (Badamhatan 1996). Буриад авгай гээгээ хоёр салаалан сүлжиж туйв хийж гоёдог гэсэн бол Үзэмчин эмэгтэй нар нэлээд өөр байна. Үзэмчин эмэгтэй, хүүхэд байхдаа эрэгтэй хүүхэд адил “тав” гээг тавьж толгойныхоо бусад хэсгийн үсийг хусуулдаг. Ингэж хоёр салаа эвэртэй байснаа арваад нас хүрэхэд толгойнхоо үсийг нийтэд нь ургуулж нэг салаа гээгтэй болж улмаар нас бие гүйцэж айлын эхнэр болохдоо хоёр салаа гээг тавина хэмээн тэмдэглэсэн байдаг (Disan 1996). Дээрхээс үзэхэд гээг үс тавих ёс нь тухайн эмэгтэйн насны байдлаас хамаарч нарийн тогтсон дэг жаягтай байсан ба нийт монгол угсаатнуудын дунд айлын эхнэр болсны дараагаас хоёр салаа гээг тавих тогтсон заншилтай байжээ.

Дүгнэлт. Эрт цагт хүмүүс өдөр тутмын ахуй амьдралдаа гээг үсээ хэрхэн засаж арчлан тордож байсан тухай асуудал энгийн мэт боловч цаанаа нарийн утга бэлгэдэл агуулсан өргөн хүрээтэй асуудал болохыг гээг үсний талаарх дээрх хэрэглэгдэхүүнүүдээс харж болно. Харин хүннүгээс өмнөх үеийн нүүдэлчид ч гэсэн гээг үсний тогтсон засал байсныг хөшөө чулууд болон хадны зургаас сэргээн төсөөлж болох бөгөөд тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь, нас хүйс, гэрлэлтийн байдал зэргийг үсээ хэрхэн ургуулж зассан байдлаас нь ялгах боломж бий.

Энэхүү өгүүлэлд судалгааны гол хэрэглэгдэхүүн болгон авч үзсэн Дөрвөлжин булшны соёлынхон нь гээг үсний заслын хувьд нэг эсвэл хоёр салаа болгон гөрсөн байдлаас хамаарч хүйсийн хувьд хоорондоо тодорхой ялгагдаж байна. Дөрвөлжин булшны хашлага чулуун дээр сийлэгдсэн гараа дээш (тэнгэр) өргөн гашуудлаа илэрхийлсэн мэт зан үйл гүйцэтгэх эрчүүд үсээ нэг салаа, тэдгээрийн ойролцоо зогсох аль эсвэл хурыцал хийж буй байдлаар харуулсан эмэгтэйчүүд үсээ хоёр салаа болгон гөржээ. Энэ байдал дөрвөлжин булшны соёлын тархалтын хүрээнд хамаарах хадны зургийн дурсгалт газруудад мөн адил ажиглагдаж буй тул тэдгээр зургуудыг энэ соёлын хүрээнд авч үзэх үндэслэл байна. Түүнчлэн нөхөн үржихүйн үйл явцыг харуулсан дөрвөлжин булшны соёлын хадны зургуудад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үс гэзгийг ялгаатай байдлаар дүрслэн харуулсан нь цаанаа нарийн утга бэлгэдлийг агуулсан байж мэднэ. Тухайлбал угсаатны зүйн мэдээнээс үзэхэд бүсгүй хүн нөхөрт гарсны дараагаас үсээ хагалж салаалан гөрөх зан үйл гүйцэтгэх нь монголчуудын дунд саяхныг болтол хадгалагдаж үлдсэн нь дөрвөлжин булшны соёлоос улбаалсан эртний уламжлал байж болох юм. Судлаачдын үзэж буйгаар дөрвөлжин булшны соёлыг үлдээгчид болон хүннү, дундад зуун болоод орчин үеийн монголчууд хооронд генетик болоод угсаа соёлын залгамж холбоо буйг олон талын судалгаагаар баталсан байдаг (Ochir et al 2020). Ер нь зөвхөн дөрвөлжин булш гэлтгүй хүрлийн хожуу, төмрийн түрүү үед Алтайн нуруугаар оршин амьдарч байсан ард түмэн ч мөн адил үс гэзгээ хүйсийн хувьд ялгаатай байдлаар засаж янзалдаг байсныг хадны зургийн арвин хэрэглэгдэхүүнээс харж болохоор байна.

Дөрвөлжин булшны зүүн талд тодорхой зайд орших зарим хөшөө чулууны нүүрэн талд хүний царай төрх, хүзүүний зүүлт, бүс, хоёр хажуу талд цагариг ээмэг, ар талд гээг үс зэргийг дүрсэлснээс үзэхэд тухайн булшны эзэнд зориулсан хүн хөшөө байх бүрэн боломжтой ба гагцхүү булш болгонд хөшөө босгодоггүй нь тухайн хүний зэрэг дэв, нас хүйстэй холбоотой эсвэл он цагийн ялгаа байж мэднэ.

НОМ ЗҮЙ

Анхсанаа Ганболд. Өвөг монголчуудын оршуулгын нэгэн зан үйл. *Монголчуудын оршуулгын зан үйл эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар, 2023.

Амартүвшин Чунаг. “Сэлэнгийн” зосон зургийн дүрслэл оршуулгын зан үйлд холбогдох нь. *УБИС-ийн Түүхийн салбарын эрдэм шинжилгээний бичиг*. Том. III, fasc. 2. Улаанбаатар, 2002.

Бадамхатан Сандагдорж. Хотон, Тува-Цаатан. *Монгол улсын угсаатны зүй*. Боть-3, Улаанбаатар, 1996.

Бадамхатан Сандагдорж, Лхагвасүрэн Ичинхорлоо. Алтайн Урианхай. *Монгол улсын угсаатны зүй*. Боть-2, Улаанбаатар, 1996.

Батболд Нацаг. Монголын говийн бүсийн хадны зураг. Улаанбаатар, 2014.

Батнасан Гончиг. Баяд. *Монгол улсын угсаатны зүй*. Боть-2, Улаанбаатар, 1996.

Батсайхан Загд. “Сэлэнгийн” хэмээх зосон зургуудыг шинээр тайлбарлах нь. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 210 (19): Улаанбаатар, 2003.

Батсайхан Загд, Амарбилэг Чинбат, Содномжамц Дамчаабадгар, Ван Лисин, Пан Лин, Даландөрөв. Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” хээрийн шинжилгээний ангийн малтлага судалгааны ажлын тайлан. МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн номын сан, Улаанбаатар, 2018.

Баярсайхан Жамсранжав, Энхболд Санжпэрлээ, Түвшинжаргал Төмөрбаатар. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын “Боролзой” ХХК-ийн 12742 дугаартай “Цавчирийн хэт” нэртэй газарт орших 548 га ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан. Монголын үндэсний музейн номын сан, Улаанбаатар, 2012.

Баярсайхан Жамсранжав. Монголын умард нутгийн буган хөшөөд. Улаанбаатар, 2017.

Bemmann J., Brosseder U. A long standing tradition – Stelae in the steppes with a special focus on the Slab grave culture. *Актуальные вопросы археологии и этнологии Центральной Азии: материалы II междунар. науч. конф., посвящ. 80-летию д.и.н., проф. П.Б. Коновалова*. Улан-Удэ, 2017.

Волков В.В. Оленные камни Монголии. Москва, 2002.

王立新、七十四、潘 玲、巴图赛汗、阿木尔毕力格、索德尼马扎木苏《蒙古国图音河流域两处石板墓群的调查与发掘》考古2023年第4期3-20页。

Болдбаатар Юндэнбат. Дөрвөлжин булшны хашлаганы зураг дахь бүжиг хийгээд сексийг тайлбарлах нь. *Төв Ази ба умард Хятадын хадны зураг олон улсын эрдэм шинжилгээний хурлын*

эмхэтгэл. Улаанбаатар, 2017.

Даваацэрэн Бямбасүрэн, Цогтбаатар Батмөнх, Анхсанаа Ганболд. Тахилгат Биндэр уул орчмын түүх соёлын дурсгал. Улаанбаатар, 20419.

Даваацэрэн Бямбасүрэн, Анхсанаа Ганболд, Мижиддорж Энхбаяр. Дөрвөлжин булшинд холбогдох нэгэн зан үйлийн тухай. *Journal of the Archaeology, History and Ethnology*. №6(5), Улаанбаатар, 2010.

Диков Н. Н. Бронзовый век Забайкалья. Улан-Удэ. 1958

Дисан Төмөрбаатар. Үзэмчин. *Монгол улсын угсаатны зүй*. Боть-3, Улаанбаатар, 1996.

冯恩学、侯璇《呼伦贝尔草原哈乌拉石板墓地踏查记》边疆考古研究, 第32辑2022年。

Гантулга Жамъян-Омбо. Хүнтэй холбоотой дүрслэл. *Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл*, Боть-3. Редактор Ц.Төрбат. Улаанбаатар, 2021.

Kovalev A. A., and Munkhbayar Ch. "The Chemurchek Ritual Complex of Khar Chuluu U T 1 at the Headwaters of the Khovd (Kobdo) River (Preliminary Report)." In *The Earliest Europeans in the Heart of Asia: The Chemurchek Cultural Phenomenon, Part II: Results of Research in the Central Part of the Mongolian Altai and the Headwaters of the Kobdo River; Sites in Xinjiang and Peripheral Lands*, St. Petersburg, 2015.

Кубарев В.Д, Цэвээндорж Д, Якобсон Э. Петроглифы Цагаан-салаа и Бага-Ойгура (Монгольский Алтай). Издательство Института археологии и этнографии СО РАН. Новосибирск–Улан-Батор–Юджин, 2005.

Очир Аюудай, Амартүвшин Чунаг, Эрэгзэн Гэлэгдорж, Гантулга Жамъян-Омбо, Түмэн Дашзэвэг, Баярсайхан Жамсранжав, Эрдэнэболд Лхагвасүрэн, Өлзийбаяр Содном, Эрдэнэбат Уламбаяр. Археологийн судалгаа: Монголчуудын гарал, Угсаа-соёлын хөгжил. Улаанбаатар, 2020.

Өлзийбаяр С, Очир Б, Уртнасан Э, Одмагнай Г, Батхуяг Э. Дорнод Монгол: эрт, дундад үед. Улаанбаатар, 2020.

Өмирбек Бихумар. Хойд Хөлцөөтийн хадны зургийн судалгаа. Улаанбаатар, 2024.

Полосьмак Н.В. Всадники Укока. Новосибирск, 2001.

Полосьмак Н.В, Богданов Е.С. Курганы Суцзуктэ (Ноин-Ула, Монголия), Часть 1. Новосибирск, 2015.

Санжмятав Товуудорж. 1988 онд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн тайлан. Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан (1987-1989), Боть 7, Улаанбаатар, 2016.

Содномжамц Дамчаабадгар, Загарпэрэнлэй Түмэнбаяр, Очирпүрэв Дүгэр, Энхбаяр Ганболд.

Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нутаг дахь түүх соёлын дурсгал. Улаанбаатар, 2024.

Сүхбаатар Гүнж, Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар, 1980.

Tsibiktarov A.D. Olennii kamni kulturi plitochnih mogil (psevdoantropomorphnie kamni, k postanovke) [Dear stones of the Slab grave cultures (pseudo anthropomorphic stones; to the formulation of the problem)]. *Ancient cultures of Mongolia, Baikal Siberia and Northern China: Reports VII international scientific conference*, Krasnoyarsk, 2016, pp.283-284.

Цэвээндорж Дамдиндорж. Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар, 2020.

Төрбат Цагаан, Ерөөл-Эрдэнэ Чимэддорж, Гунери. Эрдэнэхайрхан уулын дөрвөлжин булшны судалгаа. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 5, № 1 (344): Улаанбаатар, 2009.

Төрбат Цагаан, Эрдэнэболд Лхагвасүрэн. Дөрвөлжин булшны тархац, он цаг бусад дурсгалтай холбогдох нь. *Археологийн судалгаа: Монголчуудын гарал, Угсаа-соёлын хөгжил*. Улаанбаатар, 2020.

Төрбат Цагаан. Утга зүй ба хүнчилсэн дүр болох нь. *Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл*, Боть-3. Редактор Ц.Төрбат. Улаанбаатар, 2021.

Түвшинжаргал Төмөрбаатар, Тээвэрт үхэр тэрэг ашиглах хэлбэр, түүний үүсэл хөгжил, уламжлал. *Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, Улаанбаатар, 2022.

Түмэн Дашзэвэг, Наваан Доржпалам, Эрдэнэ Мягмар, Дорнод Монгол археологи, антропологийн судалгаа төслийн эрдэм шинжилгээний тайлан. МУИС-ийн Антропологи, археологийн тэнхимийн номын сан, Улаанбаатар, 2010.

Цэрэндагва Ядмаа, Цэвээндорж Дамдиндорж. Далан Түргэний хос толгойн хадны зураг. Улаанбаатар, 2016.

Эрдэнэбат Уламбаяр, Баяр Довдой. Хүннү нарын гээг үсний засал ба хувцас өмсгөл. *Studia Archaeologica*, Tomus XXXI, Fasc.11, Улаанбаатар, 2011.

Эрдэнэбат Уламбаяр. Дундад зууны монголчуудын оршуулах зан үйл дэх гээг үс, хувцас чимгийн дохио бэлгэдэл. *Монголчуудын оршуулгын зан үйл: уламжлал, орчин үе, чиг хандлага эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар, 2024.

Эрдэнэбаатар Диймаажав. Дөрвөлжин булш хиргисүүрийн соёл. Улаанбаатар, 2003.

REFERENCES

- Ankhsanaa Ganbold. Uvug mongolchuudiin orshuulgiin negen zan uil. [A burial ritual of the ancient Mongols] *4th Academic Conference on Mongolian Funerary Rituals*. Ulaanbaatar, 2023, pp.9-18.
- Amartuvshin Chunag. “Selengiin” zoson zurgiiin dürslel orshuulgiin zan üiltei kholbogdokh ni [The depictions in the “Selenga” ochre painted picture and their connection to funerary rites]// *Ephemeris Historiae Academiae Doctrinae Mongoli*. Tom.III, fasc. 2. Ulaanbaatar, 2002. p.18
- Badamkhatan Sandagdorj. Khoton, Tuva-Tsaatan. *Ethnography of Mongolia*. Vol. 3, Ulaanbaatar, 1996.
- Badamkhatan Sandagdorj and Lkhagvasuren I. Altain Uriankhai. *Ethnography of Mongolia*. Vol. 2, Ulaanbaatar, 1996.
- Batbold Natsag. Mongolyn gobiin büsiin khadny zurag [Research on Petroglyphs of the Mongolian Gobi]. Ulaanbaatar, 2014, p.184.
- Batnasan G. Bayad. *Ethnography of Mongolia*. Vol. 2, Ulaanbaatar, 1996, pp.219-271.
- Batsaikhan Zagd. “Selengiin” khemeeh zoson zurguudyg shineer tailbarlakh ni [New explanation of ochre in Selenge]. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 210 (19): Ulaanbaatar, 2003, pp.34-39.
- Batsaikhan Zagd, Amarbieg Chinbat, Sodnomjamts Damchaabadgar, Wang Lixin, Pan Ling, Qishisi. Mongol-Khyatadyn khamtarsan “Tüin Gol” arkheologiiin kheeriin shinjilgeenii angiiin 2018 ony maltlaga sudalgaany ajlyn tailan [Excavation and Survey Report of the Mongolian-Chinese Joint “Tüin Gol” Archaeological Field Study], Ulaanbaatar, 2018. National University of Mongolia.
- Bayarsaikhan Jamsranjav, Enkhbold Sanjperlee, Tuvshinjargal Tumurbaatar. Dundgovi aimgiin Erdenedalai sumyn “Borolzoi” LLC-ni 12742X dugaartai “Tsavchirgiin khet” nertei gazart orshikh 548 ga ashigt maltmalyn tусгай зовшооролtei talбайд khiisen arkheologiiin avran khamgaalakh khaiguul sudalgaany ajliin tailan [Report on the Archaeological Salvage Survey Conducted in the Area of the 548 ha Special Mineral License Site “Tsavchirgiin Khet,” Permit No. 12742X, Belonging to “Borolzoi” LLC, Located in Erdenedalai Soum, Dundgovi Province]. Ulaanbaatar, 2012. National Museum of Mongolia.
- Bayarsaikhan Jamsranjav. Mongolyn umard nutgiin bugan khöshööd [Deer stones of Northern Mongolia]. Ulaanbaatar, 2017, p.323.
- Bemmann J., Brosseder U. A long standing tradition – Stelae in the steppes with a special focus on the Slab grave culture. *Актуальные вопросы археологии и этнологии Центральной Азии: мат-лы II междунар. науч. конф., посвящ. 80-летию д.и.н., проф. П.Б. Коновалова*. Улан-Удэ, 2017.
- Boldbaatar Yundenbat. Dorvoljin bulshny khashlagany zurag dakhi бүжиг khiigeed seksiig tailbarlakh ni [Discussion on fertility and ritual dance motifs in the Petroglyphs of Slab burial cultures]. *The petroglyphs of Central Asia and Northern China*. Ulaanbaatar, 2017, pp.158-176.
- Davaatseren Byambasuren, Tsogtbaatar Batmunkh, Ankhsanaa Ganbold. Takhilgat Binder uul orchmyn tüüh, soyolyn dursгал [History and Cultural Heritage of the Takhilgat Binder Mountain Region]. Ulaanbaatar, 2019.
- Davaatseren Byambasuren, Ankhsanaa Ganbold, Mijiddorj Enkhbayar. Dorvoljin bulshind kholbogdoh negen zan uiliin tukhai [About the ritual of Slab burials]. *Journal of the Archaeology, History and Ethnology*. №6(5), Ulaanbaatar, 2010, pp.32-36.
- Dikov N.N. Bronzovii vek Zabaikaliya [The Bronze Age of Transbaikalia]. Ulan-Ude, 1958.
- Disan T. Uzemchin. *Ethnography of Mongolia*. Vol. 3, Ulaanbaatar, 1996, pp.129-195.
- Erdenebat Ulambayar, Bayar Dovdoi. Hünнү naryn gezeg üsnii zasal ba khuvtas ömsgöl [Xiongnu hair fashioning and dresses]. *Studia Archaeologica*, Tomus XXXI, Fasc.11, Ulaanbaatar, 2011, pp.161-179.
- Erdenebat Ulambayar. Dundad zuuny Mongolchuudyn orshuulakh zan üil dakhi gezeg üs, khuvtas chimgiin dokhio belgedel [Symbolism of hairstyle and clothing adornments in the funerary rites of the Medieval Mongols]. *Mongolian Funeral Rites: Tradition, Modernity, Trends, Conference Proceedings*. Ulaanbaatar, 2024, pp.72–85.
- Erdenebaatar, Diimaajav. Dorvoljin bulsh Khirgisüüriin soyol [Slab burials and the Khirgisuur culture]. Ulaanbaatar, 2003.
- Feng Enxue and Hou Xuan. Hulunbu’er caoyuan Haowula shiban mudi tachaji [A Field Survey Report on the Haowula Slab burials site in the Hulunbuir Grasslands].” *In Border Archaeological Research*, vol. 32, 2022, pp.56–64.
- Gantulga Jamiyan-Ombo. Khüntei kholbootoi dürslel [Human related depictions]. *Deer stone culture of Mongolia and neighboring regions*. Monograph. Volume III. Editor Ts.Turbat. Ulaanbaatar, 2021, p.448.
- Kovalev A. A., and Munkhbayar Ch. “The Chemurchek Ritual Complex of Khar Chuluu U T 1 at the Headwaters of the Khovd (Kobdo) River (Preliminary Report).” *In The Earliest Europeans in the Heart of Asia: The Chemurchek Cultural Phenomenon, Part II: Results of Research in the Central Part of the Mongolian Altai and the Headwaters of the Kobdo River; Sites in Xinjiang and Peripheral Lands*, St. Petersburg, 2015.
- Kubarev V.D, Tseveendorj D, Jacobson E. Petroglyphi Tsagaan-Salaa i Baga-Oigura (Mongoliskii Altai) [The Petroglyphs of Tsagaan salaa and Baga Oigur]. Novosibirsk, 2005, p.650.

Ochir A, Turbat Ts, Amartuvshin Ch, Eregzen G, Gantulga J, Tumen D, Bayarsaikhan J, Erdenebold L, Ulziibayar S, Erdenebat U. Arkheologiin sudalgaa: Mongolchuudyn garal, Ugsaa-soyolyn khögjil. [Research of Archaeology: Ethnogenesis of Mongols, Ethno-cultural development], Ulaanbaatar, 2020, p.279.

Polosmak, N.V. Vsadniki Ukoka [The Horsemen of Ukoka]. Novosibirsk, 2001.

Polosmak N.V and Bogdanov Ye.S. Kurgani Sutszunkte (Noun-Ula, Mongoliya) [The Suzukten mounds (Noin-Ula, Mongolia)]. Part 1. Novosibirsk, 2015.

Sanjmyatav T. 1988 ond Mongol-Zövlöltiin tuukh soyolyn hamtarsan ekspeditsiin tailan. *Mongolian archaeology: Field research reports (1987-1989)*, Volume VII, Ulaanbaatar, 2016.

Sodnomjamts Damchaabadgar, Zagarperenlei Tumenbayar, Ochirpurev Duger, Enkhbayar Ganbold. Övörkhantai aimgiin Tugrug sumyn nutag dakhi tүүkh, soyolyn dursgal [Historical and cultural monuments in the territory of Tugrug soum, Övörkhantai province]. Ulaanbaatar, 2024.

Sukhbaatar Gunj. Mongolchuudiin ertnii övөг [The ancient ancestors of the Mongols]. Ulaanbaatar, 1980.

Tsibiktarov A.D. Olennii kamni kulturi plitochnih mogil (psevdoantropomorphnie kamni, k postanovke) [Dear stones of the Slab grave cultures (pseudo anthropomorphic stones; to the formulation of the problem)]. Ancient cultures of Mongolia, Baikal Siberia and Northern China: Reports VII international scientific conference, Krasnoyarsk, 2016, pp.283-284.

Tseveendorj Damdindorj. Mongolyn ertnii urlagyn tүүkh [History of Ancient Mongolian Art]. Ulaanbaatar, 2020.

Turbat Tsagaan, Yruul-Erdene Chimeddorj, Guneri. Erdenekhairkhan uulyn dorovoljin bulshny sudalgaa. [Study of Slab burials in the Erdenekhairkhan mountain] *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 5, № 1 (344): Ulaanbaatar, 2009. Pp.93-105

Turbat Tsagaan, Erdenebold Lhagvasuren. Dorvoljin bulshnii tarkhats, on tsag, busad dursgaltai kholbogdokh ni [Slab burials and its extension, burial rite and characterization]. *Research of Archaeology: Ethnogenesis of Mongols, Ethno-cultural development*. Ulaanbaatar, 2020, pp.87-117.

Turbat Tsagaan. Utgazui ba khunchilsen dur bolokh ni [Semantics of deer stone and its representation of a human]. *Deer stone culture of Mongolia and neighboring regions*. Monograph. Volume III. Editor Ts.Turbat. Ulaanbaatar, 2021, p.448.

Tuvshinjargal Tumurbaatar. Teevert ukher ashiglah khelber, tuunii uusel khugjil, ulamjal [Forms of using oxen for transport: Their origin, development, and tradition] *Petroglyphs of ancient nomads from Central Asia*. Ulaanbaatar, 2022, pp.130-144.

Tumen Dashzeveg, Navaan Dorjpalam, Erdene Myagmar. Dornod Mongol arkheologi, antropologiin sudalgaa tösliin erdem shinjilgeenii tailan [Scientific Report of the Archaeological and Anthropological Research Project in Eastern Mongolia]. Ulaanbaatar, 2010. National University of Mongolia.

Tserendagva Yadmaa, Tseveendorj Damdindorj. Dalan Turgenii khos tolgoi khadny zurag [The Petroglyphs of Dalan Tүrgenii khos tolgoi]. Ulaanbaatar, 2016.

Ulziibayar S, Ochir B, Urtnasan E, Odmagnai G, Batkhuyag E. Dornod Mongol: Ert, dundad üed. [Eastern Mongolia: Early and Middle age], Ulaanbaatar, 2020, p.282.

Umirbek Bikhumar. Khoid Khultsuutiin khadny zurgiiin sudalgaa [The Petroglyphs of Khoid khultsuut]. Ulaanbaatar, 2024, p.286.


Volkov V.V. Olennie kamni Mongolii [Deer stones of Mongolia]. Moscow, 2002.

Wang Lixin, Qishisi, Pan Ling, Batusaikhan Zagd, Amarbileg Chinbat, Sodnomjamts Damchaabadgar. Mengguo Tuoyin he liuyu liangchu Shibao muqun de diaocha yu fajue. [Survey and Excavation of Two Stone Slab Tomb Clusters in the Tuyin River Basin, Mongolia] *Kaogu*, no. 4, 2023, pp.3–20.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.


See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>




Зураг 1. Хашлага болон хөшөө чулуун дээрээ гэзэг үсний дүрслэлтэй дөрвөлжин булшны тархалтын зураг




Зураг 2. Дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх хүний дүрслэлүүд. 1-2. Дундговь, Өлзийт, Дэл уул, 32 хүнт, 3. Баянхонгор, Өлзийт, Ар Өнцөг, 2-р булш, 4. Хэнтий, Батширээт, Биндэр уул, Дуган хад




Зураг 3. Дөрвөлжин булшны булангийн чулуун дээрх хүн, амьтны дүрслэл. 1. Дундговь, Эрдэнэдалай, Хар чулуут, 2. Баянхонгор, Өлзийт, Чулуун Онгоцот, 8-р булш, 3, 4. Баянхонгор, Өлзийт, Ар Өнцөг, 2-р булш



Зураг 4. Дөрвөлжин булшны хөшөө чулуун дээрх А хэлбэрийн гээг үсний дүрслэл. 1-4. Хэнтий, Батишрээт, Биндэр уул, Дуган хад (Davaatseren 2019), 5-6. Баянхонгор, Өлзийт, Чулуун Онгоцот, 1, 2-р булш (Batsaikhan 2018), 7. Дорнод, Чулуунхороот, Үхэрт (Davaatseren 2011), 8. Дорнод, Хөлөнбуйр, Өгөөмөр уул, 9-10. ОХУ, Чита, Анхабайн 1, 4-р булш (Tsibiktarov 2016)



Зураг 5. Дөрвөлжин булшны хөшөө чулуун дээрх В хэлбэрийн гэзэг үсний дүрслэл. 1-3. Хэнтий, Батишрээт, Биндэр уул, Дуган хад (Davaatseren 2019), 4. Өмнөговь, Манлай, Замтын хөтөл



Зураг 6. Хэмцэгийн хүн чулуу болон буган хөшөөн дээрх гэзэгний дүрслэл. 1. БНХАУ, Шинжаан, Кайнар Сентасын хүн чулуу, 2. Чемурачек 2008 №1, (Kovalev 2012), 3. Архангай, Өндөр-Улаан, Жаргалантын ам, 4. Ховд, Мөст, Баянзүрх-1 (Turbat 2018)



Зураг 7. Монголын говийн бүсийн хадны зурагт гэзэг үс дүрсэлсэн байдал. 1, 2. Өвөрхангай, Богд, Тэвш уул (Okladnikov 1981), 3. Өвөрхангай, Гучин-Ус, Паалуу (Tseveendorj 2020, 312), 4. Өмнөговь, Булган, Хавцгайт, 5. Дундговь, Өлзийт, Дэл уул, Баруун Билүүн



Зураг 8. Монгол Алтайн нурууны хадны зураг дахь гээгээ үсийг тодорхой дүрсэлсэн байдал. 1. Баян-Өлгийн, Улаанхус, Шивээт хайрхан, 2. Баян-Өлгий, Цэнгэл, Далан Түргэний хос толгой (Tserendagva, Tseveendorj 2016, 53), 3. Баян-Өлгийн, Улаанхус, Цагаан салаа, Бага Ойгур (Kubarev et al 2005)